



“БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК” ХХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юнайтед Айр Файнэнс" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот

Утас: +976-70122346; info@uaf.mn


Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Б.Болор-Эрдэнэ /"Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/



Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл	5
4. Хавсралт - Аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт	7

1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Б.Болор-Эрдэнэ, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Д.Баатаржав, ТУЗ-ийн хараат гишүүнээр С.Отгонбат нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК ажиллаж байна.

"Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр 10 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2022 оны 9 дүгээр сарын 02-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011839153
Регистрийн дугаар	6862349
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2022/08/10
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	418
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	100,000
ХБҮЦ (сая төг.)	10,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	16.8%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК нь 2022 онд ХБҮЦ-ны хүүгийн төлбөрт 418.85 сая төгрөгийг хуваарийн дагуу төлсөн бөгөөд үндсэн төлбөрийг төлж эхлээгүй байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд Хүснэгт 2-т харуулсан төлбөрийг төлнө.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үлдэгдэл	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
1	2023/03/02	10,000,000,000.00	-	414,246,575.34
2	2023/06/02	10,000,000,000.00	-	423,452,054.79
3	2023/09/04	10,000,000,000.00	5,000,000,000.00	432,657,534.25
4	2023/12/04	5,000,000,000.00	-	209,424,657.53
5	2024/03/04	5,000,000,000.00	-	209,424,657.53
6	2024/06/03	5,000,000,000.00	-	209,424,657.53
7	2024/09/02	5,000,000,000.00	5,000,000,000.00	209,424,657.53
Нийт			10,000,000,000.00	2,108,054,794.52

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант хугацааны байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 7.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2022.09.02	2022.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	10,030,730,227.03	9,323,046,320.10	-7.1%
Зээлийн дундаж үлдэгдэл	9,644,932.91	10,740,836.77	11.4%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	0.40%	0.58%	45.1%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	3.57%	4.26%	19.4%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	37.29%	36.97%	-0.9%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	52.15%	51.98%	-0.3%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	6.60	8.23	24.7%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	29.33	30.11	2.7%
Сарын дундаж төлбөрийн дүн	671,175.57	772,354.96	15.1%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	3,511,493.86	4,117,669.04	17.3%
Зээлийн тоо	1040	868	-16.5%
Зээлдэгчийн төрөл	Иргэн	Иргэн	-
Барьцаа хөрөнгийн төрөл	Автомашин	Автомашин	-
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	23,365,944,369.75	21,661,169,370.75	-7.3%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	0.42%	0.42%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс:	-	4,132,237,848.88*	-
Зээлийн үндсэн төлбөр	-	3,146,878,038.02	-
Хүүгийн төлбөр	-	983,072,936.85	-
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	-	2,286,874.01	-

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2022 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 1.15 тэрбум төгрөгийг гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны хүүгийн төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2022 оны эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 0 төгрөг, харилцах дансны үлдэгдэл 25.81 сая төгрөг байна.

"Юнайтед Айр Файнэнс" ХХК нь "Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам"-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	273	-
2	Хугацаа хэтэрсэн тул буцаан шилжүүлсэн	10	110,306,107.87
3	Багцад нэмж бүртгэсэн	111	2,549,474,641.21
	Нийт	394	2,659,780,749.08

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Бэрс Эй Би Эс Актив ТЗК” ХХК-ийг “Бэрс Финанс ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчийн хурлын Хувьцаа эзэмшигчдийн хурлын 22/21а/26 тоот шийдвэрээр ТУЗ-ийн гишүүнээр С.Отгонбат, Б.Болор-Эрдэнэ болон Д.Баатаржав нарыг тус сонгож 2022 оны 5 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн Б.Болор-Эрдэнийг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 8 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2022.05.16	ХБҮЦ гаргах тухай ТУЗ-ийн даргыг сонгох ТУЗ-ийн нарийн бичгийн даргын томилох тухай	10 тэрбум төгрөгийн ХБҮЦ-ыг нийтэд санал болгохоор болж, үнэт цаасны нөхцөл болон зээлийн шалгуурыг батлав. ТУЗ-ийн даргаар Б.Батсолонгыг сонгож, нарийн бичгийн даргаар Г.Юмсүрэнг томилов.
2	2022.05.30	ХБҮЦ гаргах тухай ТУЗ-ийн даргыг сонгох ТУЗ-ийн нарийн бичгийн даргын томилох тухай	10 тэрбум төгрөгийн ХБҮЦ-ыг нийтэд санал болгохоор болж, үнэт цаасны нөхцөл болон зээлийн шалгуурыг батлав. ТУЗ-ийн даргаар Б.Болор-Эрдэнийг сонгож, нарийн бичгийн даргаар Г.Юмсүрэнг томилов.
3	2022.06.23	ХБҮЦ хэлцэлд оролцогч талуудыг сонгох тухай, ХБҮЦ гаргахтай холбоотой гэрээ хэлцэл, журмын төслийг тус тус батлах тухай	ХБҮЦ-ын оролцогч талуудыг сонгож, нийт 6 гэрээ, 7 журмыг тус тус батлав.
4	2022.06.24	Сонирхолын зөрчилтэй их хэмжээний хэлцлийг батлах тухай	ХБҮЦ-ийн хэлцлийн хүрээнд сонирхолын зөрчилтэй их хэмжээний хэлцэлд тооцогдох гэрээ хэлцлийг байгуулах зөвшөөрлийг ТУЗ-ийн даргад олгож холбогдох гэрээ хэлцлийг байгуулав.
5	2022.08.29	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд ҮЦК-иар дамжуулан данс нээлгэх тухай	Дансыг нээлгэж захиран зарцуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгов.
6	2022.08.30	Компанийн нэр дээрх дансанд орлон гарын үсэг зурах этгээдийг томилох тухай	ТУЗ-ийн даргыг орлон гарын үсэг зурах этгээдээр үйлчилгээ үзүүлэгчийн нягтлан бодогчийг томилов.
7	2022.10.10	2022 оны 3-р улирлын санхүүгийн үйл ажиллагаа болон хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг батлах	2022 оны 3-р улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайланг мөн хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж 2022 оны 10

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
		тухай	сарын 10-нд СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт мэдэгдсэн.
8	2022.12.13	Компанийн 4 улирлын үйл ажиллагааны зардлыг баталж холбогдох зардлыг гаргахыг ХИУ-д зөвшөөрөх тухай	Зардлын төсвийг батлав.